

“БИЧИЛ ЭЙ БИ ЭС ЛОЯЛТИ ТЗК” ХХК

Санхүүгийн тайлан болон
Хараат бус аудиторын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

АГУУЛГА**ХУУДАС**

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН 1

ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН 2

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН 3

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН 4

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД 5

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

КОМПАНИЙН НЭР

Бичил Эй Би Эс лоялти тусгай зориулалтын компани

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Дарга	Н.Гантулга
Хараат бус гишүүн	М.Оюунтуяа
Хараат бус гишүүн	Д.Баатаржав

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

**Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу
гүйцэтгэх удирдлага томилоогүй**

АЛБАН ХАЯГ

**“Бичил Эй Би Эс лоялти ТЗК” ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
11 дүгээр хороо, 7 дугаар хороолол, Ногоон нуурын
гудамж, 101 дүгээр барилга, 705 тоот**

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР

9011856540

РЕГИСТРИЙН ДУГААР

8419868

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах

АУДИТОР

**Ниямазон Аудит ХХК
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
2 дугаар хороо, Чоймболын гудамж,
Нийслэлийн үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны байр,
406 тоот**

“БИЧИЛ ЭЙ БИ ЭС ЛОЯАЛТИ ТЗК” ХХК

УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Удирдлага нь санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр дуусвар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу зохистой толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн зохих зарчмуудыг сонгож, тууштай мөрдөж, үндэслэл бүхий үнэлгээ, тооцоолол хэрэглэсэн;
- Компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

“Бичил Эй Би Эс лояалти ТЗК” ХХК-ийн удирдлага 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал, энэ өдрөөр дуусвар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг мэдэгдэж байна.



НЭМЭХЖАРГАЛЫН ГАНГУЛА

ТУЗ-ИЙН ДАРГА

Улаанбаатар хот, Монгол Улс
2025 оны 4 дүгээр сарын 28



NIYAMAZON AUDIT LLC

#406, Building of Trade Union Federation,
Choimbul street, Chingeltei district,
Ulaanbaatar 15172, Mongolia
Tel: (976) 70145906, 91005906
E-mail: audit@nmz.mn

2025.04.28 № 7/25-42

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид Бичил Эй Би Эс лояалти ТЗК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусвар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланда аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Бичил Эй Би Эс лояалти ТЗК-ийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусвар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу үнэн, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Энэхүү стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар тус тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тусгасан. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол Улсын Аудитын тухай хуулийн шаардлагын дагуу компаниас хараат бус байж бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэлд жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайлангуудын талаарх аудитын дүгнэлтэд бусад мэдээлэл хамрагдаагүй бөгөөд бид түүнтэй холбоотой аудитын аливаа төрлийн баталгаа дүгнэлтийг илэрхийлэхгүй.

Санхүүгийн тайланд хүлээх удирдлагын үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу залилан болон алдаанаас улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлээс ангид бэлтгэхэд шаардлагатай гэж тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага нь компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх ба нөлөөлөх асуудлыг тодруулах, нягтлан бodoх бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан болон алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандаж, мэргэжлийн итгэл үнэмшил бүхий үнэлэлтийг хийдэг. Бид мөн:

- Залилан болон алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, тохирох аудитын горимыг боловсруулж, дүгнэлтийн үндэслэл болохуйц нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэгтэй холбоотой үүсдэг тул алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох буртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Компанийн үйл ажиллагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд мөн багтдаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг талуудын хооронд байгуулсан аудитын ажлын гэрээт захидалд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



3. ЦЭЭНЭЭ
Захирал
Ниймэлээний аудит ХХК

Улаанбаатар хот, Монгол Улс
2025 оны 04 дүгээр сарын 28

	Тодруулга	2023 мян.төг	2024 мян.төг
ХӨРӨНГӨ			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3	1,000.0	2,378,084.7
Дансны авлага	4	-	13,185,277.4
Татвар, НДШ-ийн авлага		-	-
Бусад авлага	5	-	1,533,822.4
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		-	782.4
НИЙТ ХӨРӨНГӨ		1,000.0	17,097,966.9
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
Дансны өглөг		-	-
Татварын өглөг	6	-	129,735.0
Хүүний өглөг	7	-	669,041.1
Урт хугацаат зээл	8	-	15,000,000.0
НИЙТ ӨР ТӨЛБӨР		-	15,798,776.1
ЭЗДИЙН ӨМЧ			
Энгийн хувьцаа	12	1,000.0	1,000.0
Хуримтлагдсан ашиг		-	1,298,190.8
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		1,000.0	1,299,190.8
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		1,000.0	17,097,966.9

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛГОСОН
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	Тодруулга	2023 мян.төг	2024 мян.төг
Борлуулалтын орлого	9	-	4,327,822.3
Борлуулалтын өртөг		-	-
Нийт ашиг		-	4,327,822.3
Хүүний орлого		-	-
Бусад орлого	10	-	146,514.4
Ерөнхий ба удирдлагын зардал	11	-	507,792.9
Санхүүгийн зардал		-	2,524,109.6
Татварын төлөхийн өмнөх ашиг		-	1,442,434.2
Орлогын татварын зардал		-	144,243.4
Цэвэр ашиг (алдагдал)		-	1,298,190.8

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛГОСОН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Энгийн хувьцаа мян.төг	Хуриатлагдсан ашиг мян.төг	Нийт эздиин өмч мян.төг
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	1,000.0	-	1,000.0
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000.0	-	1,000.0
Тайлант үеийн цэвэр ашиг	-	1,298,190.8	1,298,190.8
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000.0	1,298,190.8	1,299,190.8

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

	2023 МЯН.ТӨГ	2024 МЯН.ТӨГ
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Бусад мөнгөн орлого	-	131,863.0
Ажиллагчдад төлсөн	-	4,941.0
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	1,260.0
Ашиглалтын зардалд төлсөн	-	120.0
Хүүний төлбөрт төлсөн	-	1,811,636.7
Татварын байгууллагад төлсөн	-	43,717.8
Бусад мөнгөн зарлага	-	81,351.4
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	<hr/> <hr/>	<hr/> <hr/>
	-	(1,811,163.9)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	29,307,988.6
Хувьцаа болон өмчийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,000.0	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	25,119,740.0
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	<hr/> <hr/>	<hr/> <hr/>
	1,000.0	4,188,248.6
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<hr/> <hr/>	<hr/> <hr/>
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	1,000.0	2,377,084.7
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,000.0
	1,000.0	2,378,084.7

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1. Компанийн талаархи мэдээлэл

“Бичил Эй Би Эс лоялти” ХХК нь (цаашид ТЗК гэх) Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 779 дүгээр тогтоолоор **хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх** тусгай зөвшөөрөл авч тусгай зориулалтын компани болжээ.

ТЗК-ийн нийтэд санал болгон гаргах 24 сарын хугацаатай, жилийн 18.5 хувийн хүүтэй, нэг бүр нь 100.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 200.0 мянган ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг СЗХ-ны 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 87 дугаар тогтоолоор бүртгэсэн байна.

Тус компанийн гаргасан үнэт цаасны танилцуулгын товч мэдээлэл:

Оролцогч байгууллагууд

- | | |
|-------------------------------|--------------------------------------|
| ▪ Үнэт цаас гаргагч: | “Бичил Эй Би Эс лоялти ТЗК” ХХК |
| ▪ Аххны үүрэг гүйцэтгүүлэгч: | “Бичил глобус финанс ББСБ” ХХК |
| ▪ Андеррайтер | “Өлзий энд Ко капитал УЦК” ХХК |
| ▪ Зээлийн шинжилгээ гаргагч: | Си Пи Ти Эй аудит ХХК |
| ▪ Хуулийн зөвлөх: | Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН |
| ▪ Хөрөнгө итгэмжлэн удирдагч: | Юү Эй Эф Ассет менежмент ХХК |

Үнэт цаасны мэдээлэл

▪ Үнэт цаасны төрөл	Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас
▪ Нэрлэсэн үнэ /төгрөгөөр/	100,000
▪ Тоо ширхэг	200,000
▪ Жилийн хүү	18.5 хувь
▪ Хугацаа	24 сар
▪ Нийт хэмжээ	20,000.0 сая төгрөг
▪ Хүү төлөлт	Улирал тутам
▪ Үндсэн төлбөр төлөлт	Хагас жил тутам
▪ Үнэт цаасны хүүд ногдох татвар	Орлогод ногдох дүнгээс 5.0 хувь
▪ Хөрөнгийн багц	20,000.0 сая төгрөг
▪ Зээлийн тоо	1243
▪ Зээлийн чанар	100 хувь хэвийн

2. Няглан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь

Компанийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу түүхэн өртгөөр бүртгэх тогтсон зарчмыг баримтлан бэлтгэгдсэн ба энэ зарчим нь бодит үнэ цэнээрх тодорхой санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнэ болон бодит үнэ цэнийн үнэлгээн дээр үндэслэн санхүүгийн анхлан хүлээн зөвшөөрөх өөрчлөлтийг тусгасан. Компани өөрийн санхүүгийн байдлын тайланг хөрвөх чадварын дарааллаар толилуулдаг. Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд хэрэглэсэн няглан бодох бүртгэлийн хураангуйлсан үндсэн бодлогуудыг дор толилуулав. Өөрөөр заагаагүй санхүүгийн тайлагналын хугацааны туршид эдгээр бодлогыг тогтмол баримталдаг.

Няглан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, таамаглалууд

Компанийн санхүүгийн тайланг бэлтгэхийн тулд удирдлага нь санхүүгийн тайланд орлого ба зардал, хөрөнгө ба өр төлбөр, болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, холбогдох тодруулгуудыг бэлтгэхэд шаардлагатай үнэлэмж, таамаглал тооцооллуудыг хийдэг. Няглан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг зөвхөн нөлөөлж байгаа тайлант үед эсхүл ирээдүйн болон одоогийн тайлант үеүдэд нөлөөлөх бол ирээдүйн болон одоогийн тайлант үеүдэд тус тус тусгадаг.

Тайлангийн мөнгөн тэмдэгт

Эдгээр санхүүгийн тайлангуудыг барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулдаг эдийн засгийн анхдагч орчны мөнгөн тэмдэгт буюу үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр илэрхийлсэн.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь дуусвар хугацаа нь худалдан авч эзэмшснээс хойш 3 сар болон түүнээс богино хугацаагаар тодорхойлогдсон бөгөөд бодит үнэ цэнэ өөрчлөгдхөд өчүүхэн төдий эрсдлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дунд чөлөөтэй хувирдаг, компанийн удирдлага богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшиж буй бэлэн мөнгө болон банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэнэ.

Бараа материал

Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргаар тодорхойлдог ба бараа материалыг анх олж эзэмшсэн өртгөөр нь бүртгэлд тусгана. Байнгын системээр бараа материалын бүртгэлийг хөтөлж буй үед тайлант үеийн эцэс бүр бараа материалын бүртгэлээр тодорхойлсон дүн нь биет тооллогын дүнгээс зөрүүтэй байвал бараа материалын дунд залруулах бичилт хийдэг. Хэрэв бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ нь анх олж эзэмшсэн өртгөөс бага тохиолдолд бараа материалын үнэ цэнийн бууралтын гарз үүсэх бөгөөд уг гарзыг тухайн тайлант хугацаанд үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрдөг.

Цэвэр боломжит үнэ цэнэ гэж бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад бараа материалыг худалдан борлуулахаар тооцоолж буй үнээс түүнийг иж бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүн юм.

Урьдчилгаа төлбөр

Урьдчилгаа төлбөр нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч зардал нь хараахан гараагүй төлбөр эсвэл хүлээн аваагүй бараа материалын төлбөрөөс бүрдэнэ. Урьдчилгаа төлбөрийг анх өртгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг тухайн зардал нь гарсан тохиолдолд эсвэл хугацаа дусах үед ашиг, алдагдал руу болон бараа материалыг хүлээн авсан тохиолдолд холбогдох хөрөнгөнд ангилдаг.

Урьдчилгаа төлбөртэй холбоотой бүтээгдэхүүний өртөг эсвэл үйлчилгээ нь нэг жилийн дотор зарлагадах бол урьдчилгаа төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд эргэлтийн хөрөнгөөр ангилна. Бусад тохиолдолд эргэлтийн бус хөрөнгөөр ангилна.

Тайлант жилийн эцэст компани урьдчилгаа төлбөрийн дансны үнэд хяналт тавьж, үнэ цэнийн бууралт гарсан эсэхийг тодорхойлдог.

Санхүүгийн хэрэглүүр

Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрүүдийг компани тухайн хэрэглүүртэй холбоотой гэрээт тал болох үед нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх бодит үнэ цэнээр нь бүртгэх ба үүнд гэрээт харилцагчдаас үссэн дансны авлагыг СТОУС 9-ийн дагуу анх бүртгэнэ. Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр/ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэдэг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслээс бусад/-ийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг анх бүртгэлд тусгахдаа санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ дээр нэмж эсвэл өр төлбөрийн бодит үнэ цэнээс хасаж бүртгэнэ.

Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэдэг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг тухайн жилийн ашиг, алдагдлаар бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгө

Ердийн журмаар худалдах, худалдан авах санхүүгийн хөрөнгийг бодит гүйлгээ гарсан өдрөөр нягтлан бodoх бүртгэлд тусгах эсвэл бүртгэлээс хасдаг.

Ердийн журмаар худалдах, худалдан авах гэдэг нь тогтоосон хугацааны дотор эсвэл тухайн зах зээл дээр тогтсон дүрэм журмаар хөрөнгийг шилжүүлэх нөхцөлөөр санхүүгийн хөрөнгийг худалдах, худалдан авахыг хэлнэ.

Санхүүгийн хөрөнгийг ангиллаас нь хамааран анх бүртгэсний дараа хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Дараах нөхцөлүүдийг хангасан өрийн хэрэгслүүд нь дараа үеүдэд хорогдуулсан өртгөөр хэмжигдэнэ.

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой бизнесийн загвараар эзэмшдэг болон

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

- Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба гэрээний нөхцөлөөр тодорхой заасан өдрөөрх төлөгдөөгүй үндсэн төлбөрийг үлдэгдэлд тооцсон хүүгийн төлбөрөөс бүрдэх төлбөрүүдийн мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд хуваарийн дагуу хүлээн авах нөхцөлтэй байх

Дараах нөхцөлүүдийг хангасан өрийн хэрэгслүүдийг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжинэ./БДОБҮЦ/

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тул эсвэл арилжаалах зорилгоор санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилго бүхий бизнесийн загвараар эзэмшдэг болон
- Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба гэрээний нөхцөлаар тодорхой заасан өдрөөрх төлөгдөөгүй үндсэн төлбөрийг үлдэгдэлд тооцсон хүүгийн төлбөрөөс бүрдэх төлбөрүүдийн мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд хуваарийн дагуу хүлээн авах нөхцөлтэй байх

Бусад бүх санхүүгийн хөрөнгийг дараа үед ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнэ /ААБҮЦ/-ээр хэмжинэ.

Хорогдуулсан өртөг болон үр ашигт хүүгийн арга

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өрийн хорогдуулсан өртгийг тооцоолон хүүгийн орлогыг урт хугацааны туршид хуваарилах арга юм.

Худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгөөс бусад /анхлан хүлээн зөвшөөрөхдөө үнэ цэнэ нь буурсан хөрөнгө/ санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр /үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан/-ийг санхүүгийн өрийн гэрээний хугацааны эцэс гэхэд анх бүртгэсэн цэвэр дансны үнэтэй тэнцүү байхаар үнэ цэнийн бууарлтын нөөцийг хасахын өмнөх төлбөрийг өрийн хугацаа эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хуваарилахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

Санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөг гэдэг нь санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед хэмжсэн дүнгээс үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасаж анхны дүн ба дуусвар болох үеийн дүнгийн хооронд үүссэн аливаа зөрүүг үр ашигт хүүгийн арга ашиглан тооцсон хорогдуулгыг нэмж аливаа алдагдлын нөөцийг тохируулсан дүнгээр тодорхойлогдоно.

Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь аливаа алдагдлын нөөцөөр тохируулаагүй дүн байна.

Хүүгийн орлогыг анх үр ашигт хүүгийн түвшин ашиглан хорогдуулсан өртгөөр болон БДОБҮЦ-ээр хэмжигдэх бүх өрийн хэрэгслүүдийн хувьд бүртгэдэг. Зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгүүдийн хувьд хүүгийн орлогыг тухайн санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэд үр ашигт хүүгийн түвшинг ашиглах замаар тооцоолно.

Дараа тайлант үед зээлийн үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хувьд тухайн хөрөнгийн хорогдуулсан өртөгт үр ашигт хүүгийн түвшин ашиглах замаар тодорхойлно. Санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл дараа тайлант үед сайжирч санхүүгийн хөрөнгө нь зээлийн үнэ цэнийн бууралтгүй болсон ч гэсэн тооцооллыг нийт сууриар буцаахгүй.

Хүүгийн орлогыг тайлант үеийн ашиг, алдагдлаар тайлагнадаг ба санхүүгийн орлого хэсэгт ангилна.

Компани нь зөвхөн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусвар болсон эсвэл санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх ба хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийг бусдад шилжүүлсэн үед санхүүгийн хөрөнгийг данснаас хасна. Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийг данснаас хасахдаа тухайн хөрөнгийн дансны үнэ ба хүлээн авсан дүн болон авлагын нийлбэрийн зөрүүг ашиг, алдагдлын тайланда хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөр ба өмч

Гэрээний зохицуулалтын агуулга болон санхүүгийн өр төлбөр болон өмчийн хэрэгслийн тодорхойлолтын дагуу өр болон өмчийн хэрэгслийг санхүүгийн өр төлбөр эсвэл өмч гэж ангилдаг.

Өмчийн хэрэгсэл

Компанийн бүх хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсгээс хувь хүртэх нөхцөл бүхий аливаа гэрээг өмчийн хэрэгсэл гэдэг. Группээс гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дүнгээр хэмжиж бүртгэдэг.

Энгийн хувьцаа

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын аливаа нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.

Хувьцаат капиталыг буцаан худалдан авах /халаасны хувьцаа/

Хувьцаат капиталыг буцаан худалдан авсан үед аливаа татаврын нөлөөллийн дараах худалдан авахтай холбоотой гарсан шууд зардлыг багтаасан дүнгээр эздийн өмчийн бүртгэл гэж бүртгэдэг.

Буцаан худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж нэрлэх бөгөөд өмчийн өөрчлөлтийн тайланда халаасны хувьцаа гэж тайлagnадаг.

Хувьцаат хувьцааг дахин борлуулсан эсвэл дахин эргэлтэнд гаргасан үед хүлээн авсан дүнг өмчийн өсөлтөөр бүртгэдэг бөгөө тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан өсөлт, бууралтыг нэмж төлөгдсөн капитал гэж толилуулдаг.

Хуриимтлагдсан ашиг

Хуриимтлагдсан ашиг нь компанийн өмчийн эздэд ногдох ашгаас зарлсан ногдол ашгийг хассан дүн болно. Стандартад шилжилтийн шаардлагын дагуу нгтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөс үүссэн нөлөөллийг хуриимтлагдсан ашигт бүртгэдэг.

Эздийн оруулсан хөрөнгө оруулалт

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс өмнө болон бусад мөнгөн бус хөрөнгөөр сайн дурын үндсэн дээр оруулсан хөрөнгө оруулалт нь тухайн хөрөнгийн бодит үнэ цэнээр эздийн өмчид шууд бүртгэгддэг.

Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц

Хөрвүүлэлтийн нөөц нь гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайлангийн хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүү болон компанийн гадаадын охин компанид оруулсан цэвэр хөрөнгө оруулалтыг хэйджинг хийсэн өр төлбөрийн хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүнээс бүрдэнэ.

Санхүүгийн өр төлбөр

Бүх санхүүгийн өр төлбөрийг анх бүртгэсний дараа үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Компанийн санхүүгийн өр төлбөр нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хэрэгслүүдээс бүрддэг.

Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өр төлбөритийн хорогдуулсан өртгийг тооцож холбогдох хугацааны туршид хүүгийн зардлыг хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр /үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөнх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан/-ийг санхүүгийн өр төлбөрийн хугац-ааны туршид эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хорогдулахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

Санхүүгийн өр төлбөрийг данснаас хасах

Компани нь санхүүгийн өр төлбөрийг гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дууссан тохиолдолд данснаас хасна. Данснаас хасаж буй санхүүгийн өр төлбөрийг дансны үнэ ба төлсөн дүн болон өглөгийн нийлбэрийн зөрүүг ашиг, алдагдлын тайланда хүлээн зөвшөөрнө.

Орлого хүлээн зөвшөөрөлт

Бараа борлуулсны орлого, хөрөнгөө бусдад ашиглуулсны болон үйлчилгээ үзүүлсний орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр нь хэмжих ба гарсан аливаа худалдаа, үйлчилгээний буцаалт, хөнгөлөлт, үнийн бууралт зэргийг хассан цэвэр дүнгээр орлогыг хүлээн зөвшөөрнө.

Үйлчилгээ үзүүлсний орлого

Үйлчилгээний орлогод гэрээгээр гүйцэтгэсэн үйлчилгээний орлого хамаарна. Эдгээр орлогууд нь үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд орлогоор хүлээн зөвшөөрөгднө.

Үйлчилгээнээс орох орлогыг тухайн ажил гүйлгээний тайлагналын өдрөөрх гүйцэтгэлийн үйл явцтай нь уялдуулан ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үйлчилгээний гүйцэтгэлийн үйл явцыг гүйцэтгэсэн ажилд хийсэн судалгаанд үндэслэн үнэлдэг.

Бараа борлуулалтын орлого

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Компани барааны өмчлөлтэй холбогдон үүсэх мэдэгдэхүйц эрсдэл эсвэл өгөөжийг худалдан авагч талд шилжүүлсэн, борлуулсан барааныхаа өмчлөлд холбогдох аливаа удирдлагын болон хяналтын үүргийг өөртөө хадгалаагүй, орлогын дүнг найдвартай хэмжих боломжтой, тухайн ажил гүйлгээний эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлалтай бөгөөд тухайн ажил гүйлгээтэй уялдаж гарсан ба цаашид гарах зардлыг найдвартай хэмжин тодорхойлж болохоор байгаа үед орлогыг хүлээн зөвшөөрдөг.

Гадаад валютын ажил гүйлгээ

Компанийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн тайлагналын валютаас бусад валютыг (гадаад валют) ажил гүйлгээ гарсан өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэсэн.

Төгрөгөөс бусад мөнгөн тэмдэгт нь гадаад валют гэж тооцогддог ба гадаад валютаар хийгдсэн гүйлгээнүүдийг тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар төгрөг рүү хөрвүүлдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгө, хөрөнгө болон өр төлбөрүүдийн гүйлгээ хийгдсэн өдрөөс хойших ханшийн өөрчлөлтөөс үүсэн гарах өөрчлөлтийг гарсан цаг хугацаанд нь ашиг алдагдлаар бүртгэнэ.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн хөрөнгө ба өр төлбөрийг тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар хөрвүүлдэг. Ханшийн зөрүүнээс үүссэн зөрүүг бусад дэлгэрэнгүй орлогынг тайланд тусган эздийн өмчийн хэсэгт хуримуулан бүртгэнэ.

Зардал хүлээн зөвшөөрөлт

Зардлыг орлогын дэлгэрэнгүй тайланд зардлын чиг үүргийн аргыг ашиглан тайлагнадаг. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт борлуулсан барааны бүтээгдэхүүнтэй шууд холбоотой зардлууд багтдаг. Компанийн үйл ажиллагааны зардалд ерөнхий ба удирдлагын, борлуулалт ба маркетингийн болон бусад бизнесийн үйл ажиллагааны зардлууд ордог.

Санхүүгийн зардал

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрдэх ба ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөн бүртгэлд тусгагддаг. Шалгуурт нийцсэн хөрөнгийн олж бэлтгэх, барьж байгуулах ба үйлдвэрлэхэд шууд холбоотой хүүгийн зардлыг тэдгээр хөрөнгийн өртөгт оруулж бүртгэдэг. Шалгуурт нийцсэн хөрөнгө гэдэг нь түүнийг зориулалтаар нь ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгоход их хэмжээний хугацаа зарцуулдаг хөрөнгийг хэлэх ба уг хөрөнгийг ашиглах ба борлуулахад бэлэн болгох хүртэлх хугацаанд хүүгийн зардлыг хөрөнгийн өртөгт оруулдаг.

Зориулалт нь тодорхой зээлийг холбогдох хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж эхлэх хүртэл эсвэл борлуулахад бэлэн болсон нь тодорхой болсон үед зээлийг ерөнхий зээлийн капиталжуулалтын түвшинг тооцох зорилгоор зэлэйн ерөнхий санд байлгадаг. Тодорхой зээлийг түр хугацаагаар хөрөнгө оруулалт хийх зорилгоор олж авсан хөрөнгө оруулалтын орлого нь шаардлага хангасан хөрөнгөнд зарцуулагдах хүртэл хүлээгдэж байна. Зээлийн хүүгийн зардлаас хасаж хөрөнгийн зориулалт нь тодорхой зээлээрх түр хөрөнгө оруулалтаас олсон хөрөнгө оруулалтын орлогын зарцуулалтыг зээлийн өртгөөс хасаж капиталжуулан хөрөнгийн өртөгт бүртгэнэ.

Орлогын татвар

Орлогын татварын зардал нь тайлант үеийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Орлогын татварын зардлыг өмчийн дансанд шууд хүлээн зөвшөөрдөг зүйлстэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Тайлант үеийн татвар гэдэг нь өмнөх жилүүдийн татварын өрийн тохируулга болон тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эсвэл мөрдөгдөж байгаа татварын хувь хэмжээг ашиглан тухайн жилийн татвар ногдох ашиг, татварын алдагдалд суурилан хүлээгдэж буй татварын өр эсвэл авлага юм.

Татвар ногдох орлого бий болох нь тодорхой болсон бүх татвар ногдох түр зөрүүнд хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрдөг. Тайлант үеийн эцсээр хүчин төгөлдөр болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хувь хэмжээ (татварын хууль)-нд үндэслэсэн хөрөнгө нь хэрэгжих буюу өр төлбөрийг төлөх тайлант үед мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварыг хэмждэг.

3. МӨНГО БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	2023 мян.төг	2024 мян.төг
Бэлэн мөнгө	-	-
Голомт банкан дахь харилцах /3305144437/	1000.0	17,192.7
Капитрон банкан дахь харилцах /3011043254/	-	700,845.0
Капитрон банкан дахь харилцах /3011043767/	-	18.0
М банкан дахь харилцах /9000085584/	-	29.0
М банкан дахь хадгаламж	-	1,660,000.0
	1,000.0	2,378,084.7

4. ДАНСНЫ АВЛАГА

	2023 мян.төг	2024 мян.төг
Зээлийн багц - “Бичил глобус финанс ББСБ” ХХК	-	12,913,751.2
Хүүгийн авлага	-	271,526.2
	-	13,185,277.4

ТЗК нь анхны үүрэг гүйцэтгүүлэгч “Бичил глобус финанс ББСБ” ХХК-тай 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан 24/790 дугаар бүхий “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-ний дагуу Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан шаардлагыг хангасан 20,000.0 сая төгрөгийн үлдэгдэл бүхий 1243 зээлийн гэрээг багцлан шилжүүлж авчээ.

Тайлант онд 5,917.8 сая төгрөгийн үлдэгдэл бүхий 332 зээлийн гэрээг багцлан нэмж авсан ба 231.8 сая төгрөгийн үлдэгдэл бүхий 13 зээлийн гэрээг буцаан шилжүүлж, үндсэн зээлэнд 12,772.2 сая төгрөг, үндсэн зээлийн хүүгийн төлбөрт 4,038.7 сая төгрөг, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрт 8.0 сая төгрөг төлөгдсөн байна. Зээлийн багцын гүйлгээний мэдээлэл

Огноо	Нэмж авсан мян.төг	Зээлийн төлөлт мян.төг	Хасагдсан		Эцсийн үлдэгдэл мян.төг
			Багцаас буцаасан мян.төг	Эцсийн үлдэгдэл мян.төг	
Эхний үлдэгдэл					20,000,004.0
2024.04	-	1,475,701.9		-	18,524,302.1
2024.05	401,894.8	1,542,840.8		-	17,383,356.1
2024.06	602,479.9	1,761,806.5		-	16,224,029.5
2024.07	989,405.4	1,339,440.3	8,789.7		15,865,204.9
2024.08	725,259.3	1,542,500.6	67,490.9		14,980,472.7
2024.09	189,718.9	1,165,031.3	41,456.5		13,963,703.8
2024.10	1,754,255.7	1,293,627.9	43,472.8		14,380,858.8
2024.11	560,654.3	1,480,518.1	61,940.0		13,399,055.0
2024.12	694,119.3	1,170,788.1	8,635.0		12,913,751.2
нийт	5,917,787.6	12,772,255.5	231,784.9		

Тайлант хугацааны эцсийн байдлаар зээлийн багцын 96.8 хувь буюу 12,503.8 сая төгрөгийн 971 зээл хэвийн, 77.4 сая төгрөгийн 5 зээл хэвийн бус, 332.5 сая төгрөгийн 25 зээл хугацаа хэтэрсэн байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. БУСАД АВЛАГА

	2023 мян.төг	2024 мян.төг
“Бичил глобус финанс ББСБ” ХХК зээл	-	1,533,822.4
	-	1,533,822.4

6. ТАТВАРЫН ӨГЛӨГ

	2023 мян.төг	2024 мян.төг
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	-	129,592.0
Хувь хүний орлогын албан татвар	-	143.0
	-	129,735.0

Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т заасны дагуу албан татвар ногдуулах орлогын 10 хувиар татвар тооцож өглөг үүсгэн бүртгэсэн.

ТЗК-ийн ТУЗ-ийн тогтоолоор баталсан “Үйл ажиллагааны зардлын төсөв”-ийн дагуу ТУЗ-ийн 2 гишүүнд нийт 6.0 сая төгрөгийн цалин олгож, цалингаас 429.0 мянган төгрөгийн ХХОАТ суутгасан.

Суутгагчийн хувь хүнд олгосон орлогын албан татварын тайлангаар 82 хувь хүнд олгосон 390.9 сая төгрөгийн орлогоос 19.5 сая төгрөгийн, 6 байгууллагад олгосон 477.7 сая төгрөгийн орлогоос 23.9 сая төгрөгийн татвар тус тус суутган тайлагнасан.

Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.15 д заасны дагуу хөрөнгө оруулалтын сангийн худалдан авсан үнэт цаасны 986.4 сая төгрөгийн хүүний орлогоос татвар суутган аваагүй байна.

7. ХҮҮНИЙ ӨГЛӨГ

	2023 мян.төг	2024 мян.төг
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүний өглөг	-	669,041.1
	-	669,041.1

ТЗК-ийн ТУЗ-ийн 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 24/27а/03 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам”-ын дагуу үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга амжилттай явагдаж, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх өдрөөс эхлэн хүү тооцохоор тусгасан. Хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн буюу 2024 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөс хүү тооцсон.

Үнэт цаасны хүүний төлбөрийг улирал тутамд олгох заалтын дагуу Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-д заасны дагуу 5.0 хувийн татвар суутган 2024 оны 7 дугаар сарын 5-нд 900.9 сая төгрөг, 10 дугаар сарын 7-нд 910.8 сая төгрөгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн дансанд шилжүүлсэн.

2024 оны 10 дугаар сарын 05-наас хойшхи хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүний төлбөрийг өглөгөөр бүртгэсэн.

8. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ

	2023 мян.төг	2024 мян.төг
Дотоодын эх үүсвэрээс авсан зээл	-	15,000,000.0
	-	<u>15,000,000.0</u>

СЗХ-ны 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 87 дугаар тогтоолоор бүртгэсэн ТЗК-ийн нийтэд санал болгох 24 сарын хугацаатай, жилийн 18.5 хувийн хүүтэй, нэг бүр нь 100.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 200.0 мянган ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөрийг урт хугацаат өр төлбөрөөр бүртгэсэн. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны эхний төлөлт 5,000.0 сая төгрөгийг хуваарийн дагуу 2024 оны 10 дугаар сарын 07-нд төлсөн.

9. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

	2023 мян.төг	2024 мян.төг
Зээлийн хүүгийн орлого		
2024.02 улирал	-	1,595,905.5
2024.03 улирал	-	1,429,180.0
2024.04 улирал	-	1,302,736.8
	<u>-</u>	<u>4,327,822.3</u>

ТЗК-ийн орлого нь анхны үүрэг гүйцэтгүүлэгч “Бичил глобус финанс ББСБ” ХХК-иас шилжүүлэн авсан зээлийн хүүний орлогоос бүрдэнэ.

10. БУСАД ОРЛОГО

	2023 мян.төг	2024 мян.төг
Хүүгийн орлого		
	<u>-</u>	<u>146,514.4</u>
	<u>-</u>	<u>146,514.4</u>

Капитрон банканд 3011043254 дугаар дансанд 2,112.0 сая төгрөгийн хадгаламж байршуулж 59.9 сая төгрөгийн, Тээвэр хөгжлийн банканд 9000081121 дугаар дансанд 4,801.3 сая төгрөгийн хадгаламж байршуулж 86.5 сая төгрөгийн хүүгийн орлого тус тус олсон. Харилцах дансны үлдэгдэлд тооцсон хүүгийн орлого 0.1 сая төгрөг байна.

11. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

	2024 мян.төг
Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний төлбөр	Цуглуулсан төлбөрийн 2.5 хувь
Арилжааны шимтгэл	420,473.9
Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний төлбөр	Арилжааны дүнгээс тооцдог
Захиргааны үйлчилгээний шимтгэл	260.8
ТУЗ-ийн гишүүдийн цалин, нийгмийн даатгалын шимтгэл	Сар бүр тогтмол
	66,640.0
	13,500.0
	6,630.0

Бусад зардал	120.0
Шимтгэл хураамж	168.2
	507,792.9

12. ЭНГИЙН ХУВЬЦАА

	Эзэмшил хувь	2024 мян.төг
Хувьцаа эзэмшигч “Бичил глобус финанс ББСБ” ХХК	100	1,000.0
	100	1,000.0

13. ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Тооцсон дүн Мян.төг
Нийт хөрөнгө	17,097,966.9
Өөрийн хөрөнгө	1,299,190.8
Урт хугацаат өр төлбөр	15,000,000.0
Богино хугацаат өр төлбөр	798,776.1
Үйл ажиллагааны зардал	507,792.9
Хөрөнгийн зохистой харьцаа	7.97
Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	100